



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/359

Улаанбаатар хот

Улирлын томуугийн эсрэг  
вакцинаар дархлаажуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг 2024 оны 08 дугаар сарын 26-наас 09 дүгээр сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Улирлын томуугийн эсрэг "GCFLU" вакцин, дагалдах хэрэгслийн хуваарийг нэгдүгээр, "GCFLU" вакциныг хэрэглэх зааврыг хоёрдугаар, Улирлын томуугийн вакцинжуулалтын хамралтын мэдээний маягтыг гуравдугаар, Улирлын томуугийн вакцин хийхэд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас авах зөвшөөрлийн хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Улирлын томуугийн эсрэг вакцинаар жирэмсэн эмэгтэйчүүд, эрсдэлт бүлгийн хүн ам, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн 6 сартайгаас 5 настай хүүхдийг дархлаажуулах ажлыг зохион байгуулахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.


4. Дархлаажуулалтын 10 хоногоор заавал хийх товлолын дархлаажуулалтаас хоцорсон 0-15 насны хүүхдийг нөхөн дархлаажуулах, дархлаажуулалтын ач

холбогдлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (С.Өнөрсайхан), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

5. Вакцин, дагалдах хэрэгслийг хүлээн авч, эргэлтийн хөрөнгөөр бүртгэн, зарцуулалтад нь хяналт тавьж, санхүүгийн тайланд тусгахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ж.Байгалмаа), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

6. Дархлаажуулалтын 10 хоногоор цэцэрлэгийн хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг хамтатган зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газар (Д.Баярболд)-т даалгасугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын  
2024 оны 08 сарын 23 өдрийн 400 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ "GCFLU"  
ДӨРВӨНЦЭНТ ВАКЦИН, ДАГАЛДАХ ХЭРЭГСЛИЙН  
ХУВААРЬ

Нэг. Аймгийн эрүүл мэндийн газар

Д/д	Аймаг	Вакцинд хамруулах зорилтот бүлэг				Шаардлагатай вакцин, тариур	
		6 сартайгаас 5 хүртэлх насны хүүхдүүд	Жирэмсэн эмэгтэйчүүд	Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	Эрсдэлт бүлгийн хүн ам /65 болон түүнээс дээш насны хүмүүс, архаг хууч өвчтэй хүмүүс/	Олгох хүн тун 4 цэнт	Тариур 0.5 мл
		50%	10%	50%	50%		
1	Архангай	4,250	90	450	960	5,750	5,750
2	Баян-Өлгий	6,093	148	550	819	7,610	7,610
3	Баянхонгор	4,340	98	650	782	5,870	5,870
4	Булган	2,550	60	270	750	3,630	3,630
5	Говь-Алтай	2,696	55	400	549	3,700	3,700
6	Говьсүмбэр	920	20	150	150	1,240	1,240
7	Дархан-Уул	4,747	103	330	1121	6,301	6,301
8	Дорноговь	3,218	73	400	629	4,320	4,320
9	Дорнод	4,065	85	560	820	5,530	5,530
10	Дундговь	2,260	50	350	570	3,230	3,230
11	Завхан	3,187	70	590	763	4,610	4,610
12	Орхон	4,822	103	360	1025	6,310	6,310
13	Өвөрхангай	5,347	120	660	1183	7,310	7,310
14	Өмнөговь	3,840	75	350	616	4,881	4,881
15	Сүхбаатар	3,302	70	370	616	4,358	4,358
16	Сэлэнгэ	4,666	100	300	1134	6,200	6,200
17	Төв	4,041	90	300	1119	5,550	5,550
18	Увс	4,170	95	680	655	5,600	5,600
19	Ховд	4,569	100	600	731	6,000	6,000
20	Хөвсгөл	6,065	138	650	1277	8,130	8,130
21	Хэнтий	3,668	81	540	831	5,120	5,120
<b>Нийт</b>		<b>82,816</b>	<b>82,816</b>	<b>1,824</b>	<b>9,510</b>	<b>17,100</b>	<b>111,250</b>

Хоёр. Нийслэлийн эрүүл мэндийн газар

Д/д	Дүүрэг	Вакцинд хамруулах зорилтот бүлэг				Шаадлагатай вакцин, тариур	
		Эрүүл мэндийн байгууллагын ажилтан	Жирэмсэн эмэгтэйчүүд	6 сартайгаас 5 хүртэлх насны хүүхдүүд	Эрсдэлт бүлгийн хүн ам /65 болон түүнээс дээш насны хүмүүс, архаг хууч өвчтэй хүмүүс/	Олгох хүн тун 4 цэнт	Тариур 0.5 мл
1	Багануур дүүргийн эрүүл мэндийн төв	300	28	2,594	318	3,240	3,240
2	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв	30	5	442	53	530	530
3	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	540	200	24,121	2,569	27,430	27,430
4	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	960	375	33,326	10,609	45,270	45,270
5	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв	320	40	3,748	422	4,530	4,530
6	Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв	920	345	26,145	10,540	37,950	37,950
7	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	530	225	12,842	1,753	15,350	15,350
8	Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв	860	240	25,710	2,150	28,960	28,960
9	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв	460	130	13,104	1,586	15,280	15,280
10	Наркологийн эмнэлэг	50				50	50
11	Энэрэл эмнэлэг	70				70	70
12	Сэргээн засах клиникийн эмнэлэг	100				100	100
13	Сэргээн засах хүүхдийн бяцхан тэмүүлэл	100				100	100
14	Нийслэлийн зоонозын өвчин судлалын төв	50				50	50

15	“Амгалан амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	200				200	200
16	“Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	400				400	400
17	“Хүрээ амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	150				150	150
18	Нийслэлийн түргэн тусламжийн төв	360				360	360
19	Нийслэлийн шүд эрүү нүүрний төв	100				100	100
20	Нийслэлийн эрүүл мэндийн газар	60				60	60
Нийт		<b>6,560</b>	<b>1,588</b>	<b>142,032</b>	<b>30,000</b>	<b>180,180</b>	<b>180,180</b>

Гурав. Эрсдэлт бүлгийн хүн амыг  
дархлаажуулах улирлын томуугийн эсрэг  
вакцины хуваарь


3.1. Эрүүл мэндийн байгууллага

Д/д	Эрүүл мэндийн байгууллага	Олгох хүн тун 4 цэнт	Тариур 0.5 мл
1	Эрүүл мэндийн яам	150	150
2	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	200	200
3	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	300	300
4	Улсын гуравдугаар төв эмнэлэг	200	200
5	Халдварт өвчин судлалын үндэсний төв	540	540
6	Хавдар судлалын үндэсний төв	200	200
7	Зооноз өвчин судлалын үндэсний төв	100	100
8	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	560	560
9	Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II	400	400
10	Төрийн албан хаагчдын нэгдсэн эмнэлэг	140	140
11	Цэргийн төв эмнэлэг	200	200
12	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	50	50
13	Гэмтэл, согог судлалын үндэсний төв	150	150
14	Арьсны өвчин судлалын үндэсний төв	100	100
15	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв	300	300
16	Геронтологийн үндэсний төв	30	30
17	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	100	100
18	Эмгэг судлалын үндэсний төв	50	50
19	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	100	100
20	Эрүүл мэндийн хөгжлийн төв	30	30
21	Хүүхдийн төв сувилал	100	100
22	Төмөр замын нэгдсэн эмнэлэг	100	100
23	АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг	300	300
24	429 дүгээр хаалттай хорих анги – төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг	100	100
25	401 дүгээр хаалттай хорих анги- нэгдсэн эмнэлэг	100	100
26	Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги – нэгдсэн эмнэлэг	100	100
<b>Нийт</b>		<b>4,700</b>	<b>4,700</b>

### 3.2. Бусад салбарын байгууллага

Д/д	Бусад байгууллага	Олгох хүн тун 4 цэнт	Тариур 0.5 мл
1	Улсын их хурлын тамгын газар	220	220
2	Ерөнхийлөгчийн тамгийн газар	80	80
3	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	100	100
4	Гадаад харилцааны яам	100	100
5	Сангийн яам	50	50
6	Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яам	50	50
7	Онцгой байдлын ерөнхий газар	750	750
8	Хил хамгаалах ерөнхий газар	500	500
9	Зэвсэгт хүчний жанжин штаб	500	500
10	Тагнуулын ерөнхий газар	300	300
11	Цагдаагийн ерөнхий газар	750	750
12	Төрийн тусгай хамгаалалтын алба	200	200
13	Дотоод хэргийн их сургууль	200	200
14	Үндсэн хуулийн цэц	70	70
	<b>Нийт</b>	<b>3,870</b>	<b>3,870</b>

Эрүүл мэндийн сайдын  
2024 оны 08 сарын 23 өдрийн 1359 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ЭСРЭГ  
“GCFLU” ДӨРВӨН ЦЭНТ ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ  
ЗААВАР

Улирлын томуугийн эсрэг “GCFLU” дөрвөн цэнт вакцин нь 2024/2025 оны томуугийн улиралд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болгосон томуугийн вирусийн эсрэгтөрөгчийг идэвхгүйжүүлж гаргаж авсан, ДЭМБ-ын чанар, аюулгүй байдлын урьдчилсан шалгуур хангасан вакцин юм. Вакцины найрлагад орсон томуугийн вирусийн дөрвөн дэд хэвшинжээр үүсгэгдсэн халдвараас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ.

**Тодорхойлолт:**

GCFLU дөрвөн цэнт вакцин нь эсрэгтөрөгч чанарыг нь хадгалахын тулд өндөгний үр хөврөлд тарьж өсгөвөрлөсөн, томуугийн вирусийг задалж, идэвхгүйжүүлэх аргаар гаргаж авсан өнгөгүй, бүдэг цайвар өнгө бүхий вакцин юм.

**Найрлага:**

0.5 мл-т агуулагдах найрлага:

Идэвхтэй хэсэг: Томуугийн вирусийн цэвэршүүлж, идэвхгүйжүүлсэн антиген.....120µg  
А хүрээний Victoria/4897/2022 IVR –238 (H1N1) .....30µg  
А хүрээний Thailand/8/2022 IVR-237 (H3N2) ..... 30µg  
В хүрээний /Austria/1359417/2021 BVR-26..... 30µg  
В хүрээний /Phuket/3073/2013.....30µg

Нэмэлтээр натри, калийн хлорид, гидрофосфат натри, калийн дигидроген фосфат, тиомерсал, тарилгын ус агуулна.

**Савлагаа:**

Нэг хүн тун нь 0,5 мл, нэг флаконд 10 хүн тунгаар савлагдсан. Өнгөгүй шингэн хөвмөл.

**Заалт:**

Томуугийн А болон В хүрээний вирусээр үүсгэгдсэн томуугийн халдвараас урьдчилан сэргийлж 6 сар ба түүнээс дээш насны хүмүүст хэрэглэнэ.



### **Тун ба тарих арга:**

Вакциныг гарын бугалганы (делтойд) булчинд тарьж хэрэглэнэ.

- 6 сар ба түүнээс дээш насны хүмүүст: 0.5 мл-ээр нэг удаа тарина.

### **Эсрэг заалт:**

Вакцинжуулахын өмнө тухайн хүнээс асуумж авч, бодит үзлэг хийнэ. Үзлэгээр дараах эмгэгийн аль нэг нь илэрсэн тохиолдолд вакцинжуулахыг зөвлөхгүй.

- Халууралт, хоол тэжээлийн дутагдал;
- Зүрх судас, бөөр, элэгний өвчний хурц үе шатанд байгаа хүн;
- Амьсгалын замын цочмог халдвар, бусад идэвхтэй халдварт өвчнүүд;
- Өвчний далд үе болон эдгэрэлийн шатандаа байх үед;
- Вакцины найрлагад орсон бодист анафилаксийн шок илэрч байсан өгүүлэмжтэй;
- Өндөг, тахианы мах, тахианы гаралтай бүтээгдэхүүнд хэт мэдрэг хариу урвал өгч байсан;
- Өмнө нь томуугийн вакцин хийлгээд 2 хоног халуурсан эсвэл тууралт гарсан харшлын өгүүлэмжтэй;
- Сүүлийн нэг жилийн хугацаанд таталтын шинж тэмдэг илэрсэн;
- Өмнө нь томуугийн вакцин хийлгэснээс хойш 6 долоо хоногийн дотор Гиллен-Барын хамшинж илэрч байсан эсвэл мэдрэлийн эмгэгтэй хүн;
- Дааврын эмчилгээ болон дархлаа дарангуйлах, дархлаа сэргээх эмчилгээ хийлгэж байгаа хүн;

### **Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэл:**

- Халуурах, толгой өвдөх, чичрэх, ядрах, тайван бус болох, хоолонд дургүй болох, бөөлжих зэрэг ерөнхий болон тариулсан газарт улайх, хөндүүрлэх, хавдах зэрэг хэсэг газрын урвалын шинж илэрч болох бөгөөд 2-3 өдрийн дараа хэвийн байдалд ордог.
- Ховор тохиолдолд энцефаломиелит илрэх ба энэ нь вакцин хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дотор халуурах, толгой өвдөх, татах, дискинези, ухаан алдах эдгээр шинжээр ихэвчлэн илэрдэг.
- Мэдрэлийн тогтолцооны түр зуурын хямрал ховор тохиолдож болно. Үүнд саажилт, мэдрэлийн өвчин, тархины цус хуралт, Гиллен-Барын хамшинж зэрэг орно.
- Маш ховор тохиолдолд харшлын урвал эсвэл анафилаксийн шок үүсч болно.

Дээрх шинж тэмдэг илэрвэл эмч, эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандаж, эмчийн зааврын дагуу эмчилгээг хийх хэрэгтэй.

### **Анхааруулга:**

- Вакцин хийхийн өмнө эмчийн үзлэгт хамруулна.

- Томуугийн вакциныг бусад вакцинтай 1 сарын зайтай хийнэ.
- Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцинд хамрагдах насны хүүхдүүд (9 сар, 2 нас) эхлээд УГУ вакцинд товлолын дагуу хамрагдаж, 1 сарын дараа томуугийн вакцинд хамрагдаж болно.
- Хэрэв томуугийн эсрэг дархлаажуулалтад хамрагдахаар ирсэн хүүхэд тухайн өдрөөс өмнөх 30 хоногийн дотор улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг (УГУ) товлолт вакцин эсвэл улаанбурхан, улаануудын эсрэг (УУ) нэмэлт вакцин хийлгэсэн бол томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулахгүй. УГУ эсвэл УУ вакцин хийлгэснээс хойш 30 хоногийн дараа томуугийн вакцин хийлгэнэ.
- Тарилгын стандартыг баримтлан ажиллана.
- Задалсан вакциныг дараах нөхцөлийг хангасан тохиолдолд 7 хоногийн дотор хэрэглэж болох бөгөөд задалсан огноо, цаг, минутыг заавал тэмдэглэнэ.
  - Вакциныг +2 - +8 хэмд хадгалсан
  - Вакциныг хэрэглэхийн өмнө тухайн вакцины нэр, дуусах хугацаа, вакцины шошгоны заагуур, флакон цуурсан, дотор нь гадны биет хөвсөн, бохирдсон, тунадас үүссэн, өнгө өөрчлөгдсөн эсэхийг нягталж шалгасны дараа хэрэглэнэ.
  - Халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажилласан.
- Тарилга хийсэн хэсэг газрыг бохирдуулахгүй, цэвэр байлгах, цохихгүй, маажихгүй байх талаар зөвлөнө. Мөн дархлаажуулалтын дараах урвал хүндрэл илэрсэн тохиолдолд эмчид яаралтай хандахыг вакцин хийлгэж байгаа хүнд зөвлөнө.
- Дархлаа дутмагшилтай өвчтөнүүдэд вакцины эсрэгбиеийн урвал хангалтгүй үүсч болно.

### **Жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд**

Вакцин хийхийн өмнө жирэмсэн болон хөхүүл эмэгтэйг эмчийн үзлэгт хамруулна. Жирэмсний 14-өөс 36 долоо хоногтой жирэмсэн эмэгтэйд томуугийн вакцин хийж болно.


### **Хадгалалт, тээвэрлэлт, савлагаа**

- Вакциныг +2 - +8 хэмд гэрлээс хамгаалж, хадгалан тээвэрлэнэ.
- Халууны нөлөөнд өртсөн эсэхийг вакцин шошгоны монитормыг ашиглан хянана.
- Хөлдөөж болохгүй.
- Нэг хүн тун нь 0,5 мл, нэг флаконд 10 хүн тунгаар буюу 5 мл-ээр савлагдсан.

**Хүчинтэй хугацаа:** 2025 оны 06 дугаар сарын 23

**Үйлдвэрлэгч:** Грийн кросс корпораци, БНСУ

Эрүүл мэндийн сайдын  
2024 оны 08 сарын 23 өдрийн 439 дугаар  
тушаалын гуравдугаар хэсэглэлт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИНЖУУЛАЛТЫН  
ХАМРАЛТЫН МЭДЭЭ

МАЯГТ 1. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ (6 сартайгаас 5 настай хүүхэд)

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр					ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь	6-12 сар	2 нас	3 нас	4 нас	5 нас	
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
9										
10										

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 80086829 утсаар болон [nicmongolia@nccd.gov.mn](mailto:nicmongolia@nccd.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 2. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ (Жирэмсэн эмэгтэй)

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр			ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь	16-24	25-34	35-49	
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 80086829 утсаар болон [nicmongolia@nccd.gov.mn](mailto:nicmongolia@nccd.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 3. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ (65 болон түүнээс дээш настай хүмүүс)

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр			
		Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь	65-75	75-85	85+	ДДУХ
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 80086829 утсаар болон [nicmongolia@nccd.gov.mn](mailto:nicmongolia@nccd.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

МАЯГТ 4. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ (Архаг, хууч)

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр				
		Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь	16-24	25-49	50-64	65-аас дээш	ДДУХ
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 80086829 утсаар болон [nicmongolia@nccd.gov.mn](mailto:nicmongolia@nccd.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

**МАЯГТ 5. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ (Эрүүл мэндийн байгууллага)**

№	Байгууллагын нэр	Нийт			Мэргэжилээр			Насны бүлэг				ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь	Эмч	Сувилагч	Бусад	16-24	25-49	50-64	≥65	

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 80086829 утсаар болон [nicmongolia@nccd.gov.mn](mailto:nicmongolia@nccd.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

**МАЯГТ 6. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМ (Бусад албан байгууллага)**

№	Байгууллагын нэр	Нийт			Насны бүлгээр				ДДУХ
		Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамралтын хувь	16-24	25-49	50-64	≥65	

Хамралтын мэдээг өдөр бүрийн өглөө 10:00 цагаас өмнө нэгтгэн 80086829 утсаар болон [nicmongolia@nccd.gov.mn](mailto:nicmongolia@nccd.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ.

Мэдээ гаргасан:.....

Мэдээг хянасан:.....

Эрүүл мэндийн сайдын  
2024 оны 08 сарын 13 өдрийн 439 дугаар  
тушаалын дөрөвдүгээр хавсралт



УЛИРЛЫН ТОМУУГИЙН ВАКЦИН ХИЙХЭД  
ХҮҮХДИЙН ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧААС АВАХ  
ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Миний хүү/охин ..... овогтой .....нь  
..... настай. ....дүүргийн ..... хорооны .....сургууль, цэцэрлэгт  
суралцдаг.  
Эцэг эх асран хамгаалагч Би хүүхдэдээ улирлын томуугийн вакцин хийлгэхийг  
зөвшөөрч байна.  
Улирлын томуугийн эсрэг вакцины зааврыг уншиж, танилцсан болно.  
Гарын үсэг: эцэг/ эх / асран хамгаалагч .....  
Огноо: 2024 оны ..... дугаар сарын ..... өдөр

*Тайлбар:* Хүүхдүүдийг улирлын томуугийн эсрэг вакцинд хамруулахаас өмнө энэхүү зөвшөөрлийн хуудсыг ангийн багш, өрхийн эмч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчид заавал танилцуулж, гарын үсэг авсан байна. Сүүлийн нэг сарын хугацаанд товллын болон сайн дураар томуугийн вакцинд хамрагдаагүй байх.